



МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 1/79

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд заасан Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт шилжүүлсүгэй.

2. Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхийг хэрэгжүүлэхдээ Зөвшөөрлийн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон холбогдох захиргааны хэм хэмжээний актыг баримталж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /З.Энхболд/-т үүрэг болгосугай.

3. Эрх шилжүүлсэнтэй холбоотой бэлтгэл ажлыг хангахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /З.Энхболд/, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, удирдлагаар хангаж ажиллахыг Хөдөлмөрийн бодлогын газар /Д.Ренчиндорж/, энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т тус тус даалгасугай.



З.ЭНХ-АМГАЛАН

D: 2024 on 12 sar tushaal

151240265